

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төрийн нууцыг задруулах, үрэгдүүлэх үйдлийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар 1986 оны болон 2002 оны Эрүүгийн хуульд тусган төрийн нууцыг задруулах гэмт хэрэгт 8 жил хүртэл, төрийн нууцыг үрэгдүүлэх гэмт хэрэгт 2-3 жил хүртэл хорих ял оногдуулж байсан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах төрийн нууцыг задруулах гэмт хэрэг нь төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, эд зүйлсийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд бусад этгээдэд мэдээллийг санаатайгаар дамжуулснаар төгсдөг. Харин төрийн нууцыг үрэгдүүлэх гэмт хэрэг нь төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, эд зүйлсийг хадгалах, хамгаалах журам зөрчсөн (санаатай, эсхүл болгоомжгүйгээр) үйлдлийн улмаас нууц мэдээлэл бусдын мэдэлд орох нөхцөл бүрдэж, хор уршиг учирснаар төгсдөг онцлогтой.

2015 оны Эрүүгийн хуулиар төрийн нууцыг задруулах, үрэгдүүлэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого илүү уян хатан (эрх хасах, торгох, зорчих эрх хязгаарлах, хорих) болж, эрүүгийн хариуцлага гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх шударга ёсны зарчмыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Төрийн нууцын тухай хуулийн төсөлд төрийн нууцын зэрэглэлийг “нууц”, “маш нууц”, “онц чухал нууц” гэж тогтоосоно бөгөөд эдгээр зэрэглэлд хамаарах мэдээллийг үндэсний аюулгүй байдалд учруулах хор хохирлоос хамааруулан ялган зүйлчлэх, түүнд тохирсон ялын бодлогыг тодорхойлох шаардлагын хүрээнд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.12 дугаар зүйл (Төрийн нууцыг задруулах), 19.13 дугаар зүйл (Төрийн нууцыг үрэгдүүлэх) гэмт хэргийн үндсэн объектод “маш нууц”, “онц чухал нууц” зэрэглэлийн мэдээлэл хамаардаг. Төрийн нууцын тухай хуулийн төсөлд “нууц” зэрэглэлийн мэдээллийг төрийн нууцад хамааруулахаар тусгасан тул уг мэдээллийн аюулгүй байдлыг Эрүүгийн хуулиар хамгаалах шаардлага бий болж байна.

Энэ хүрээнд “нууц” зэрэглэлд хамаарах төрийн нууц мэдээллийг задруулах, үрэгдүүлэх тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тодорхойлж ялын бодлогын хувьд хамгийн бага, сонгох боломжтой байдлаар томъёолон тусгасан.

Өөрөөр хэлбэл, эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчимд нийцүүлэн “Төрийн нууцыг задруулах”, “Төрийн нууцыг үрэгдүүлэх” гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн нь төрийн нууц мэдээллийн нууцын зэрэглэлээс шууд хамаарах буюу оногдуулах ял шийтгэлийн хэмжээг харилцан адилгүй байхаар хуульчилсан болно.